

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Соёл урлагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/011/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Улиастай сум	Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: Boldbaatarakh@audit.gov.mn
2025 он	Ахлах аудитор: Г.Заяа Утас: 90088028 Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.22 № 231

танай _____ -ны № _____ -т

СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА
М.НЯМДОРЖ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл урлагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёл урлагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 488.9 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 311.9 сая төгрөгийн, нийт 800.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулжээ.

Аудитын гол асуудал

Дотоод хяналтаар 15 сумын соёлын төвийн эрхлэгч нарт ээлжийн амралттай байх хугацаандаа 2.3 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү тооцож олгосныг илрүүлээгүй, газрын ажилтнуудад 0.2 сая төгрөгийн унааы хөнгөлөлт илүү тооцож олгосон, холбогдох журам зөрчин 2 ажилтанд 2.9 сая төгрөгийн урамуулал олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 112.2 сая төгрөгийн санхүүжилтийг Соёл урлагийн газрын дансаар дамжуулан зарцуулсан, 2024 оны 4-12 сард соёл урлагийн салбарын байгууллагуудын удирдлагуудын ажлыг дүгнэн ур чадварын нэмэгдэл олгох шийдвэрийг гаргасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D/disk/Албан бичиг/Дүгнэлт

810502391

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 -р сарын 31 өдөр

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	2,987,500.00	56,029,308.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,580,000.00	49,893,608.90
31200	Банканд байгаа мөнгө	2,850,000.00	49,893,608.90
31210	Төгрөг	2,850,000.00	49,893,608.90
31218	Ахмадын сангийн харилцах	2,850,000.00	49,893,608.90
33	АВЛАГА	137,500.00	2,000,000.00
33500	Бусад авлага	137,500.00	2,000,000.00
33510	Байгууллагаас авах авлага	137,500.00	
35	БАРАА МАТЕРИАЛ		4,135,700.00
35400	Хангамжийн материал		4,135,700.00
35410	Бичиг хэргийн материал		533,500.00
35420	Аж ахуйн материал		3,602,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	53,135,267.44	146,981,107.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	53,135,267.44	146,981,107.08
39200	Биет хөрөнгө	53,135,267.44	146,981,107.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл		67,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл		(3,375,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	42,639,800.00	43,039,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(8,516,895.10)	(17,044,855.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,762,000.00	58,762,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(3,903,777.46)	(5,979,977.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	750,000.00	750,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(83,500.00)	(158,500.00)
39217	Номын фонд	3,487,640.00	3,487,640.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	56,122,767.44	203,010,415.98
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	7,800.00	37,543,608.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,800.00	37,543,608.90
41300	Өглөг	7,800.00	37,543,608.90
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,800.00	
413201	Бичиг хэргийн өглөг	7,800.00	
41360	Бусад өглөг		37,543,608.90
41361	Байгууллагад төлөх өглөг		37,543,608.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	56,114,967.44	165,466,807.08
51	Засгийн газрын хувь оролцоо	56,114,967.44	165,466,807.08
51200	Хуримтлагдсан үр дүн	56,114,967.44	165,466,807.08
51210	Өмнөх үеийн үр дүн	61,082,212.27	56,122,767.44

51220	Тайлант үеийн үр дүн	(4,967,244.83)	109,344,039.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	56,122,767.44	203,010,415.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 -р сарын 31 өдөр

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	745,973,500.00	830,554,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,500,000.00	67,500,000.00
1200	Нийтлэг татварын бус орлого	16,500,000.00	67,500,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	16,500,000.00	67,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	729,473,500.00	763,054,100.00
1310	Улсын төсвөөс	479,808,000.00	488,920,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	479,808,000.00	488,920,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	249,665,500.00	263,634,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	133,555,500.00	147,634,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	105,850,000.00	113,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,260,000.00	3,000,000.00
1330	Төсвийн захирагчаас		10,500,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		10,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	750,940,744.83	721,210,060.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	750,940,744.83	721,210,060.36
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	740,712,804.24	650,991,175.78
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	212,751,684.77	324,370,103.00
210101	Үндсэн цалин	137,955,368.18	197,101,442.00
210102	Нэмэгдэл	54,724,277.19	80,429,561.20
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	11,316,500.00	14,472,299.80
210104	Урамшуулал	8,755,539.40	32,366,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,426,270.67	39,902,606.42
210201	Тэтгэврийн даатгал	18,220,275.09	27,381,901.51
210202	Тэтгэмжийн даатгал	2,061,748.65	3,138,701.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,649,398.94	1,569,350.55
210204	Ажилгүйдлийн даатгал	412,349.67	1,562,529.54
210205	Эрүүл мэндийн даатгал	4,123,498.32	6,250,123.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,252,350.00	6,257,700.00
210304	Байрны түрээс	6,252,350.00	6,257,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,205,811.00	34,822,356.00
210401	Бичиг хэрэг	2,975,100.00	3,065,550.00

210402	Тээвэр, шатахуун	15,442,251.00	19,353,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,660.00	1,467,400.00
210404	Ном, хэвлэл		1,500,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,481,800.00	9,435,686.00
2105	Нормативд зардал		2,450,000.00
210502	Хоол, хүнс		2,450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	568,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	568,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,537,600.00	8,406,600.00
210702	Дотоод албан томилолт	13,537,600.00	8,406,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,457,677.00	75,137,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,457,677.00	75,137,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	437,040,410.80	159,076,310.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	409,949,050.00	86,288,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	17,812,200	58,374,150.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	9,279,160.80	14,054,160.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,227,940.59	70,218,884.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,450,000.00	31,911,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,000,000.00
213208	Хөдөө оро нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг		24,411,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,450,000.00	6,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,280,972.59	38,307,584.58
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,280,972.59	38,307,584.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(4,967,244.83)	109,344,039.64
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(4,967,244.83)	109,344,039.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 -р сарын 31 өдөр

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	739,781,808.00	800,597,708.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	739,781,808.00	800,597,708.90
1310	Улсын төсвөөс	479,808,000.00	488,920,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	479,808,000.00	488,920,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	253,973,808.00	263,634,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	133,555,500.00	147,634,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	105,850,000.00	113,000,000.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,568,308.00	3,000,000.00
1330	Төсвийн захирагчаас	6,000,000.00	48,043,608.90
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,000,000.00	48,043,608.90
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	736,931,808.00	713,154,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	736,931,808.00	713,154,100.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	726,703,867.41	642,935,215.42
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	214,396,388.37	324,370,103.00
210101	Үндсэн цалин	132,097,166.82	197,101,442.00
210102	Нэмэгдэл	62,272,182.15	80,429,561.20
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	11,271,500.00	14,472,299.80
210104	Урамшуулал	8,755,539.40	32,366,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,514,851.04	39,765,106.42
210201	Тэтгэврийн даатгал	16,726,045.03	27,244,401.51
210202	Тэтгэмжийн даатгал	1,947,201.07	3,138,701.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,557,760.88	1,569,350.55
210204	Ажилгүйдлийн даатгал	389,440.15	1,562,529.54
210205	Эрүүл мэндийн даатгал	3,894,403.91	6,250,123.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,252,350.00	6,257,700.00
210304	Байрны түрээс	6,252,350.00	6,257,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,146,251.00	36,958,056.00
210401	Бичиг хэрэг	2,967,300.00	3,599,050.00
210402	Тээвэр, шатахуун	10,642,251.00	19,353,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,660.00	1,467,400.00
210404	Ном, хэвлэл	1,748,240.00	3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,481,800.00	9,537,886.00
2105	Нормативд зардал		2,450,000.00
210502	Хоол, хүнс		2,450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	568,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	568,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,975,100.00	8,406,600.00
210702	Дотоод албан томилолт	13,975,100.00	8,406,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	21,457,677.00	75,137,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,457,677.00	75,137,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	426,141,250.00	149,022,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	408,329,050.00	90,288,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	17,812,200.00	58,734,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,227,940.59	70,218,884.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,450,000.00	31,911,300.00
213204	Ажип олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,000,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг		24,411,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,450,000.00	6,500,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,280,942.59	38,307,584.58
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,280,972.59	38,307,584.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	2,850,000.00	87,443,608.90
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		40,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		40,400,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		40,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		40,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)		40,400,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,850,000.00	47,043,608.90
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,850,000.00
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,850,000.00	49,893,608.90

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	НИЙТ ДҮН
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			61,082,212.27	61,082,212.27
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			61,082,212.27	61,082,212.27
3	Тайлант үеийн үр дүн			(4,967,244.83)	(4,967,244.83)
4	2024 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл			56,114,967.44	56,114,967.44
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			7,800.00	7,800.00
6	Тайлант үеийн үр дүн			109,344,039.64	109,344,039.64
7	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			165,466,807.88	165,466,807.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12-р сарын 31 өдөр

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	%
71702	Соёл урлаг	488,920,000	477,939,500	10,980,500	97.75
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	450,528,200	450,528,200		100
12	Татварын бус орлого		450,528,200	(450,528,200)	
1200	Тусламжийн орлого		450,528,200	(450,528,200)	
122005	Төсвөөс санхүүжих		450,528,200	(450,528,200)	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	450,528,200	450,528,200		100

21	УРСГАЛ ЗАРДАЛ	450,528,200	412,416,515.42	38,111,684.58	91.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,528,200	412,416,515.42	38,111,684.58	91.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	356,133,900	324,370,103	31,763,797	91.08
210101	Үндсэн цалин	207,368,700	197,101,442	10,267,28	95.05
210102	Нэмэгдэл	101,464,400	80,429,561.2	21,034,838.8	79.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,419,100	14,472,299.8	1,946,800.2	88.14
210104	Урамшуулал	30,881,700	32,366,800	(1,485,100)	104.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,516,600	39,765,106.42	4,751,493.58	89.33
210201	Тэтгэврийн даатгал	31,758,600	27,244,401.51	4,514,198.49	85.79
210202	Тэтгэмжийн даатгал	3,189,500	3,138,701.03	50,798.97	98.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,594,700	1,569,350.55	25,349.45	98.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,594,700	1,562,529.54	32,170.46	97.98
210205	Эрүүл мэндийн даатгал	6,379,100	6,250,123.79	128,976.21	97.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,257,700	6,257,700		100
210304	Байрны түрээс	6,257,700	6,257,700		100
2104	Хангамж, бараа материалын зардал	17,120,000	16,060,056	1,059,944	93.81
210401	Бичиг хэрэг	3,600,000	3,599,050	950	99.97
210402	Тээвэр, шатахуун	6,000,000	5,999,720	280	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000	1,467,400	932,600	61.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэжлийн үстгэл	120,000		120,000	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000	4,993,886	6,114	99.88
2107	Томилолт, зочны зардал	6,000,000	5,974,400	25,600	99.57
210702	Дотоод албан томилолт	6,000,000	5,974,400	25,600	99.57
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	10,500,000	9,992,000	508,000	95.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000	9,992,000	8,000	99.92
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000		500,000	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000	9,997,150	2,850	99.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000	5,000,000		100
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000	4,997,150	2,850	99.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг				
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	27,411,300	27,411,300		100
12	Татварын бус орлого		27,411,300	(27,411,300)	
12200	Тусламжийн орлого		27,411,300	(27,411,300)	

122005	Төсвөөс санхүүжих		27,411,300	(27,411,300)	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,411,300	27,411,300		100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,411,300	27,411,300		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,411,300	27,411,300		100
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох дэмжлэг	27,411,300	24,411,300		100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000	3,000,000		100
81901	Соёл урлаг хөгжүүлэх	10,980,500		10,980,500	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,980,500		10,980,500	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,980,500		10,980,500	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,980,500		10,980,500	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	10,980,500		10,980,500	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,980,500		10,980,500	
72209	Залуучууд болон оюутнууд		10,980,500	(10,980,500)	
83115	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд		10,980,500	(10,980,500)	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж		10,980,500	(10,980,500)	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		10,980,500	(10,980,500)	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	16			
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12		
620003	Үйлчлэх ажилтан	3	3		
620004	Гэрээт ажилтан				

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 -р сарын 31 өдөр

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	263,634,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	263,634,100.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	259,938,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,898,000.00

210402	Тээвэр, шатахуун	13,354,000.00
210404	Ном, хэвлэл	3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,544,000.00
2105	Нормативд зардал	2,450,000.00
210502	Хоол, хүнс	2,450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	568,000.00
210604	Урсгал засвар	568,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,432,200.00
210702	Дотоод албан томилолт	2,432,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,165,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	86,165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,425,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,688,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	53,737,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,695,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	195,900.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	195,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	263,634,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	263,634,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	263,634,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	147,634,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	113,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	3,000,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Соёл урлагийн газрын чиг үүрэг:

- ✓ Соёлын хууль тогтоомжийн дагуу соёл, урлагийг хөгжүүлэх, иргэний соёлын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;
- ✓ Соёлын байгууллагын үйл ажиллагааг зохицуулж, хууль тогтоомжид заасны дагуу төрөөс санхүүжүүлэх, тэдгээрт дэмжлэг, тусалцаа үзүүлэх, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авах;
- ✓ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан соёлын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах;
- ✓ Харьяалах нутаг дэвсгэрийн соёлын байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;
- ✓ Соёлын статистик мэдээлэл, соёлын байгууллагын тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх.

Аймгийн Соёл урлагийн газрын эрхэм зорилго: Монгол үндэсний бахархал, эх оронч үзлийг төлөвшүүлэн, аймгийн хэмжээгээр соёл урлаг, аялал жуулчлалын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэдийг соён гэгээрүүлнэ.

Аймгийн Соёл урлагийн газрын СТРАТЕГИЙН ЗОРИЛТ:

- ✓ Соёл, урлагийн хөгжлийн чиг, хандлагыг тодорхойлох
- ✓ Эрх зүйн орчныг боловсронгуй болгож, нэгдсэн удирдлагаар хангах
- ✓ Соёл, урлагийг хөгжүүлэх, дэмжих
- ✓ Соёлын өвийн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх
- ✓ Соёлын инноваци, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
- ✓ Монгол Үндэсний соёлыг сурталчлан таниулах, нөлөөллийг нэмэгдүүлэх
- ✓ Бодлого хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах
- ✓ Үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх
- ✓ Хүний нөөц, төсөв, санхүү, технологийн болон бусад нөөцийг үр ашигтай удирдах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн соёл урлагийн газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Соёлын тухай хууль
2. Төсвийн тухай хууль,
3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /2024.01.01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн/
- ✓ Нийгмийн даатгалын багц хууль /2024.01.01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн/
- ✓ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал хүчингүй болж, 2023 оны “Ангилал шинэчлэн батлах тухай” 211 дүгээр тушаал гарсан ч системийн хөгжүүлэлтийн ажлуудыг үе шаттайгаар төлөвлөн хийж байгаатай холбоотой тус журмыг мөрдөж эхлээгүй байна.
- ✓ Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалаар зардлын эдийн засгийн ангилал, санхүүгийн тайлангийн маягыг шинэчлэн баталсан ч 2024 оны төгсгөлд буюу 2025 оны А/03 дугаар тушаалаар уг шийдвэрийг хүчингүй болгосон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзсэн. Дотоод аудитын нэгж ажилладаггүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн соёл урлагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн соёл урлагийн газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй, жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 103,145.8 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,850.0	49,893.6	47,043.6
Авлага	137.5		-137.5
Бараа материал		4,135.7	4,135.7
Үндсэн хөрөнгө	53,135.3	146,981.1	93,845.8
Нийт хөрөнгө	56,122.8	201,010.4	144,887.6
Өр төлбөр	7.8	37,543.6	37,535.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	56,115.0	163,466.8	107,351.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	56,122.8	201,010.4	144,887.6

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 47,043.6 мянган төгрөгөөр өссөн нь Сумдын соёлын төвүүд ахмадын сангаа байгуулж чадалгүй, Соёл урлагийн газрын ахмадын сан руу шилжүүлсэн, байгууллагын ахмадын сангийн зарцуулаагүй үлдэгдэл зэрэгтэй холбоотой байна.

Бараа материалын дансны данс үлдэгдэл 4,135.7 мянган төгрөгөөр өссөн нь 36,246.8 мянган төгрөгийг бараа материал худалдан авч, 32,111.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 93,845.8 мянган төгрөгөөр өссөн нь Соёлын яамнаас үнэ төлбөргүй ирсэн 67,500.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг бүртгэн, 40,400.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 37,535.8 мянган төгрөгөөр өссөн нь Сумдын соёлын төвүүд ахмадын сангаа байгуулж чадалгүй, Соёл урлагийн газрын ахмадын сан руу шилжүүлснийг өглөгөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 107,351.8 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дансны өсөлттэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 488,920.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаар, нийт зарлагыг 488,920.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 488,920.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 450,808.3 мянган төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь санхүүжилтээс 38,111.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 147,634.1 мянган төгрөгийн, Соёлын сайдын багцаас 72,000.0 мянган төгрөгийн, бусад орлогоор 7,000.0 мянган төгрөгийн, Соёл урлагийн газраас 37,000.0 мянган төгрөгийн, нийт 263,634.1 мянган төгрөгийг орлого бүрдүүлсэн.

Нэмэлт орлогоос шатахууны зардалд 11,354.0 мянган төгрөгийг, ном хэвлэлийн зардалд 3,000.0 мянган төгрөгийг, урсгал засварт 568.0 мянган төгрөгийг, албан томилолтын зардалд 2,432.0 мянган төгрөгийг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлд 4,544.0 мянган төгрөгийг, хоолны зардалд 2,450.0 мянган төгрөгийг,бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 86,165.0 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 122,697.0 мянган төгрөгийг тус тус зарцуулан 195.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	80101	2024 он	Үндсэн үйл ажиллагааны	91.5 хувь хэрэгжсэн	450,528.2	412,416.5

			төсвийг зориулалтын дагуу зарцуулна			
2	80802	2024 он	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын төсвийг зориулалтын дагуу зарцуулна	100 хэрэгжсэн хувь	27,411.3	27,411.3
3	81901	2024 он	Соёл урлагийг хөгжүүлэх төсвийг зориулалтын дагуу зарцуулна	Хэрэгжээгүй	10,980.5	
4	83115	2024 он	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн төсвийг зориулалтын дагуу зарцуулна	100 хэрэгжсэн хувь		10,980.5

Үндсэн үйл ажиллагааны төсвөөс цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 31,763.8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 4,751.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 1,060.0 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 25.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 508.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна. Энэ нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг илүү төлөвлөсөнтэй холбоотой байна.

Соёл урлагийг хөгжүүлэх төсвийг зориулалтын дагуу зарцуулалгүй дээд шатны төсөв захирагчийн шийдвэрээр тайлант онд шинээр нэмэгдсэн нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрт гүйлгэн зарцуулсан байна.

4.АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Соёл урлагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Соёл урлагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 05 дугаартай албан тоотор ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 830,818.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,308.2 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Соёл урлагийн газрын шилэн дансны мэдээллийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн байна* гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Соёл урлагийн газрын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,119,627.0	2	1,119,627.0	100%
Зөвлөмж	9	203,639,781.55	9	187,505,318.0	94.4%
Нийт дүн	11	204,759,408.55	11	188,624,945	

Хэрэгжээгүй зөвлөмжийг дурдах, шалтгааныг тайлбарлах

Баянтэс, Их-Уул, Сантмаргац, Тэлмэн сумдын Соёлын төвүүдэд бусад сумдын Соёлын төвөөс 1-2 төрийн үйлчилгээний ажилтны орон тоог илүү батлан 64,537,854 төгрөгийн цалин олгосон зөрчлийг арилгуулахаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна. Энэ нь Баянтэс сумын соёлын төвийн зөрчил арилаагүй тул тус байгууллагад албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 185,878.2 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс аудитын явцад 5,771.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,494.6 мянган төлбөрийн акт тогтоож, 112,240.0 мянган төгрөгийн зөвлөмжийг аймгийн Засаг даргад, 65,371.8 мянган төгрөгийн зөвлөмжийг аймгийн Соёл урлагийн газрын даргад өглөө.

Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд авлага, бараа материалын дүнг 5,500.0 мянган төгрөгөөр, үр дүнгийн тайланд зардлын дүнг 271.8 мянган төгрөгөөр буруу илэрхийлснийг тус тус залруулсан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.1 Төлбөрийн акт

Ажилтнуудад 214.2 мянган төгрөгийн унааны хөнгөлөлтийг, 15 сумын соёлын төвийн эрхлэгчид ээлжийн амралттай байх хугацаанд нь 2,280.4 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тус тус илүү тооцож олгосон зөрчлийг илрүүлэн төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага хүргүүлээгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох" журмын 3.3-д "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно" гэж заасан шаардлагыг хангаагүй 2 ажилтанд 2,917.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон. .
2. Соёлын сайд, ХНХ-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/166,А/63,А/73 тоот тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудын ажлыг 2024 оны 2-4 улиралд дүгнэн 62,454.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгох шийдвэрийг гаргасан байна. Ажил дүгнэсэн байдлыг шалгахад удирдах ажилтнуудын манлайлах чадвар, ажлын арга барил, асуудал шийдвэрлэх чадварын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаагүй байхад 22 сумын соёлын төвийн эрхлэгчид 9 сарын турш 15-25 хувийн ур чадвар олгосон.

Өгсөн зөвлөмж:

1. Ажилтнуудад хууль журам зөрчин мөнгөн шагнал олгосон зөрчлийг таслан зогсоох;
2. Соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудын ажлыг дүгнэн, ур чадварын нэмэгдэл олгох шийдвэрийг гаргахдаа үйлчлүүлэгчийн тав тух, соёлын хүртээмж, орон зай, уран бүтээлийн чанар, сэтгэл ханамжийг бүрдүүлсэн байдал, хамт олны төлөвшил, байгууллагын соёлд гарсан өөрчлөлт, мэдлэг туршлагаа хуваалцах чадвар, шаардлагатай мэдээ мэдээллийг цуглуулж асуудал шийдвэрлэсэн байдал зэргийг хангасан нотлох баримтад үндэслэх;
3. Соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгох шийдвэр гаргахдаа бусдаас илүү чадварлаг, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй, тухайн салбарт үр ашигтай ажилласныг баримтжуулж хэвших;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 07 дугаар сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Зардлыг зөрүүлэй бүртгэсэн	1	271.8			1	271.8	1	271.8				
Авлагыг дутуу бүртгэсэн	1	2,000.0	1	2,000.0			1	2,000.0				
Бараа материалыг дутуу бүртгэсэн	1	3,500.0	1	3,500.0			1	3,500.0				
Дүн	3	5,771.8	2	5,500.0			3	5,771.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Холбогдох журмын шаардлагыг хангаагүй 2 ажилтанд мөнгөн шагнал олгосон.	1	2,917.0					1	2,917.0				

Соёлын сайд, ХНХ-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/166,А/63,А/73 тоот тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаагүй байхад 22 сумын соёлын төвийн эрхлэгчид 9 сарын турш 15- 25 хувийн ур чадвар олгосон.	1	62,454.8					1	62,454.8			
Аймгийн ОНХС- ийн санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллага руу шилжүүлэлгүй, аймгийн Соёл урлагийн газрын дансаар дамжуулсан зөрчил илэрсэн	1	112,240					1	112,240			
15 соёлын төвийн эрхлэгчид ээлжийн амралттай байх хугацаанд нь ур чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон	1	2,280.4	1	2,280.4							
Ажилтнуудад унааны хөнгөлөлтийг илүү тооцож олгосон	1	214.2	1	214.2							
Дүн	5	180,106.4	2	2,494.6			3	177,611.8			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР
 Д.БАТ-УНДРАА
 Г.ЗАЯА

Огноо: 2025-02-25